Temenos Core

Суурь бүртгэлийн систем

Дэлхийн 950 гаруй банк Temenos Core-ийг иргэдийн (retail), бизнес, корпорейт банк, хөрөнгийн удирдлага болон төлбөр тооцооны салбарт ашиглаж байна. Платформ дээрх модульчлагдсан (composable) чадамж, тэргүүлэх хэрэгслүүдэд шууд хандах боломжийн ачаар банкууд хурдацтай шинэчлэгдэж, зах зээлд тэргүүлэх шинэлэг банкны үйлчилгээг нэвтрүүлсээр байна.



Temenos Core – Иргэдийн банкны үйлчилгээ

Харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хувь хүнд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох уян хатан, шуурхай, цогц үйлчилгээ

Temenos Core – Бизнес банкны үйлчилгээ

Бизнес банкны харилцагч нарт банкны шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх боломж олгох дэвшилтэт функцүүдийг санал болгох үйлчилгээ

Temenos Core – Корпорейт банкны үйлчилгээ

Корпорацийн банкны бүх чиглэлийг хамарсан, бие даан нэвтрүүлэх боломж бүхий банкны цогц систем

Temenos Core – Хөрөнгийн удирдлага

Харилцагчийн үнэт цаас, деривативын арилжааг дэмжих, олон төрлийн санхүүгийн хэрэгслийн арилжаа, төлбөр тооцоо, кастодианы бүрэн мөчлөгийг цогцоор нь хариуцах үйлчилгээ

Temenos Core – Санхүүгийн хүртээмж дэмжигч байгууллага

Санхүүгийн хүртээмжийг дэмжигч байгууллагуудад үйл ажиллагаагаа богино хугацаанд эхлүүлж, өөрсдийн зорилтот харилцагчдын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд шуурхай нэвтрүүлэх боломжийг санал болгох үйлчилгээ

Temenos Core – Исламын банк

Исламын банкуудад иргэдийн, бизнес, корпорейт банк болон худалдааны санхүүжилтийн чиглэлээр санхүүгийн уян хатан шийдэл санал болгох, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Temenos Core – Төлбөр тооцоо

Уян хатан тохируулах боломжтой функцүүд болон хүчирхэг хэрэгсэл, фреймворкуудын (framework) цогц шийдлээр дамжуулан санхүүгийн байгууллагуудад төлбөр тооцооны чадавхаа өргөжүүлж, сайжруулах боломжийг олгох үйлчилгээ

Модульчлагдсан банкны чадамжууд суурь системийн шинэчлэлийг хурдасгана

Temenos нь банкны бүх сегментэд зориулсан өргөн хүрээтэй, өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн ашиглах боломжтой, цогц функц бүхий суурь системийн тэргүүлэх чадавхуудыг санал болгодог. Модульчлагдсан бүтэц нь банкуудад Temenos-ийн цөм шийдлийг өөрт тохирох хэлбэрээр оновчтой ашиглах боломжийг олгоно.

Temenos нь хэрэгцээнд нийцүүлэн хослуулан ашиглах боломжтой банкны чадавхуудыг санал болгож, банкуудад одоо ашиглаж буй суурь банкны технологио үе шаттайгаар шинэчлэх боломжийг бүрдүүлдэг. Суурь системийг бүхэлд нь нэг дор шинэчлэхийн оронд банкууд хамгийн их шаардлагатай тодорхой хэсгүүдээ сонгон шинэчилж, хослуулан ашиглах боломж дээр суурилсан, бие даасан шийдлүүдийг бий болгох боломжтой.

Хуучин суурь системийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Temenos-ийн өргөн хүрээний функц бүхий, найдвартай, хэрэгцээнд нийцүүлэн хослуулах боломжтой Core чадавхуудаар үе шаттайгаар сольж, системээ аажмаар шинэчлэх боломжтой. Програм хангамжийн бага нөөц шаардсан архитектур, сервер шаардахгүй нэвтрүүлэлт болон орчин үеийн API-уудын тусламжтайгаар банкууд бизнесийн стратегиудаа нэг нэгээр нь үе шаттай хэрэгжүүлэх боломжтой.

Temenos-ийн хэрэгцээнд нийцүүлэн хослуулан ашиглах боломжтой чадавхуудыг on-premises, cloud болон SaaS хэлбэрээр ашиглах боломжтой бөгөөд энэ нь банкуудад суурь системийн орчноо ирээдүйн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. Temenos Banking Platform дээр банкууд Payments, Digital, Financial Crime Mitigation болон AI чадавхуудыг ашиглан банкны үйл ажиллагааны end-to-end процессыг цогцоор нь шинэчлэх боломжтой.

950+ банк Temenos Core Banking ашигладаг

600+ банк Temenos Digital ашигладаг

150+ улс орон

Нэг платформ Нэг код бааз

Хамгийн өндөр өргөтгөх чадвар, хамгийн бага нөөц зарцуулалт

Банкууд шинэ бизнесийн загварыг дэмжихийн тулд их хэмжээний гүйлгээг өндөр гүйцэтгэлтэй боловсруулахын зэрэгцээ тогтвортой хөгжлийн зорилтуудаа хангах шаардлагатай. Хэрэгцээнд нийцүүлэн хослуулан ашиглах боломжтой суурь банкны чадавхуудыг нэвтрүүлснээр Temenos Core нь банкны үйл ажиллагааны нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахад хэрхэн дэмжлэг үзүүлэх боломжтой.

temenos

Гол чадавхуудыг тасралтгүй ашиглах боломж

Бүтээгдэхүүн загварчлалын хэрэгслүүдийг тасралтгүй ашиглах боломж

Тасралтгүй сайжруулж, шинэчлэх боломж

Ямар ч орчинд суурилуулах боломж

Батлагдсан SaaS хэлбэрээр ашиглах боломж

Temenos SaaS
Банкны салбарын инноваци

Харилцагч байгууллагууд Temenos-ийн SaaS үйлчилгээг ашигласнаар найдвартай, аюулгүй, тасралтгүй, тогтмол шинэчлэгддэг үйлчилгээг харилцагч нарт санал болгож, тэдэнд бүрэн төвлөрч, бүтээгдэхүүн үйлчилгээгээ илүү хурдан хүргэх нөхцөл бүрддэг.

Temenos SaaS нь дэлхийн банкуудаар баталгаажсан, банкны үйл ажиллагааг эхнээс нь дуустал хамарсан өргөн хүрээний үйлчилгээг санал болгодог бөгөөд 30-аас дээш зохицуулалттай зах зээлд иргэдийн, бизнес, корпорейт болон хувийн банкны харилцагчдын сегментүүдэд ашиглагдаж байна. Temenos SaaS нь AWS болон Azure үүлэн дэд бүтцэд суурилан хэрэгждэг.

Харилцагчдын маань бизнесийн гол цөм

Qik

QIK Banco нь Temenos SaaS дээрх Temenos Core-ийг ашиглан Доминиканы 10 сая гаруй хэрэглэгчид богино хугацаанд хүрч, банкны технологи, аюулгүй байдал болон үйлчилгээний стандартыг хамгийн өндөр түвшинд ханган ажиллаж байна.

BIL

Banque International a Luxembourg нь иргэдийн, корпорейт болон хувийн банкны бизнесийн чиглэлүүдэд 30 гаруй жил ашиглагдсан хуучин Core системээ бүрэн шинэчилж, үүний зэрэгцээ өгөгдлийн чанар, ил тод байдал болон төлбөрийн хурдыг сайжруулах зохицуулагч байгууллагын шаардлагуудыг хангасан.

EQ Bank

EQ Bank нь Temenos Core-ийг Temenos SaaS руу шилжүүлэх ажлыг ердөө 12 сарын дотор амжилттай дуусгасан. Cloud технологийг нэвтрүүлснээр бүтээмжээ нэмэгдүүлж, сар бүр 40 гаруй шинэчлэлийг бодит орчинд нэвтрүүлэх боломжтой болсон бөгөөд эцсийн харилцагчдадаа өдөр бүр шинэ үнэ цэн хүргэж байна.

Дэлгэрэнгүй: www.temenos.com/products/get-in-touch/

Иргэдийн банк | **Бизнес банк** | **Корпорейт банк**